



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН  
ЭТГЭЭДЭД

2020.03.17 № 03/653  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Шинжээчээр хамтран ажиллах урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитад “Газрын тос, нефтийн завсрын бүтээгдэхүүний эрх зүйн орчныг судалж дүгнэх, бүтээгдэхүүний чанарын шалгалтад хөндлөнгийн хяналт тавьж дүгнэлт гаргах, аудитын багт мэргэжлийн зөвлөгөө өгөх” зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Шинжээч нь УАГ-АД/22-016 дугаартай ажлын даалгаврын дагуу газрын тосны болон нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлэх бодлого боловсруулах, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудыг хамруулж, чиг үүргийн хэрэгжилтийн 2017-2021 оны тайлан, баримт материалуудыг үзэж, дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргах бөгөөд ажлын зорилтын хүрээнд доорх зөвлөх үйлчилгээг хуанлийн 10 хүртэл хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого үр нөлөөтэй байгаа эсэхэд дүгнэлт гаргах;
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний зохицуулалт, хууль, эрх зүйн орчны хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэхэд дүгнэлт гаргах;
- Аудитын дүгнэлт зөвлөмж боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах.

Шинжээч нь аудитын хамрах хүрээний байгууллагуудтай аудитын багаар дамжуулан харилцаж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, энэхүү ажлын даалгаварт тусгасан ажлыг Төрийн аудитын байгууллагаас баримтлах бодлого, чиглэл, зорилтын хүрээнд чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

Мэдээллээ ирүүлж буй шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, санхүүгийн дэлгэрэнгүй санал, урилгад хавсаргасан маягтаар нэмэлт мэдээллээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;

- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/:

Шинжээч нь тухайн аудитад оролцоход Төрийн аудитын байгууллагатай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллах ба дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай байна. Үүнд:

- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний чиглэлээр мэргэжил боловсрол эзэмшсэн, магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэшсэн инженер, багш байх;
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний чиглэлээр дүгнэлт гаргаж байсан бол давуу тал болно.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөн хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдээллээ 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 10 минутын дотор дараах цахим хаягаар /[tsend-ayushn@audit.gov.mn](mailto:tsend-ayushn@audit.gov.mn), [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)/ pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, 409 тоот өрөө Үндэсний Аудитын газар, Утас: 26-35 33.

БАТЛАВ  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ Я.САРАНСҮХ



2022.03.15

## ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 13 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар...  
22-016

Улаанбаатар хот

**Ажлын зорилго:** “Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын хүрээнд Газрын тос, нефтийн завсрын бүтээгдэхүүний талаар эрх зүйн орчныг судалж дүгнэх, аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж гаргахад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж шинжээчээр ажиллахад энэхүү ажлын зорилго оршино.

**Эхлэх хугацаа:** 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

**Дуусах хугацаа:** 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

**Байршил:** Улаанбаатар хот

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

1.1 Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу “Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитыг гүйцэтгэхэд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийг аудитад татан оролцуулах шаардлагатай байна.

Хот суурин газрын төвлөрөл, түүнийг дагасан тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдсэнээр газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жилээс жилд өсөж, хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаагаас импортын хэмжээ нэмэгдэж, 2020 оны байдлаар 1.4 сая тоннд хүрсэн байна.

Мөн 2016 оноос эхлэн онцгой албан татваргүй нефть-химийн бүтээгдэхүүний импорт эрс нэмэгдэж, 2018 онд 2015 онтой харьцуулахад керосины импорт 24.5 дахин, газрын тосны хүнд фракцын нэгдэл 14.4 дахин, хөнгөн нэрлэгийн фракц нафта 2.1 дахин буюу хамгийн их хэмжээнд хүрч өссөн байна.

Импортоор орж ирж байгаа нефтийн завсрын бүтээгдэхүүнийг автобензин, дизель түлштэй хольж /хуурамч шатахуун/ шатахуун түгээх станцуудаар борлуулж байна гэсэн мэдээлэл олон нийтийн сүлжээгээр явж, нийтийн эрх ашиг хөндөгдөж байгааг харгалзан холбогдох төрийн эрх бүхий байгууллагууд цагдаагийн байгууллагатай хамтран шалгалт явуулж олон нийтэд мэдээлж, дүгнэлт гарган ажиллаж байна.

Иймд төрийн аудитын байгууллага эрх бүхий төрийн байгууллагуудын шатахууны чанар, үнэ тарифтай холбогдуулан хийсэн хяналт шалгалттай давхардуулалгүй Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны баталсны дагуу “Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн”-д аудит хийхээр төлөвлөгөөг боловсруулав.

## ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Аудитад газрын тосны болон нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлэх бодлого боловсруулах, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудыг хамруулж, чиг үүргийн хэрэгжилтийн 2017-2021 оны тайлан, баримт материалуудыг үзэж, дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргана.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

3.1 Шинжээч нь Газрын тос, нефтийн завсрын бүтээгдэхүүний эрх зүйн орчныг судалж дүгнэх, аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого үр нөлөөтэй байгаа эсэхэд дүгнэлт гаргах;	Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д <i>“Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”;</i>	<ul style="list-style-type: none"> <li>Газрын тосны болон нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого үр нөлөөтэй байгаа эсэхэд санал, дүгнэлт боловсруулах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Холбогдох УИХ-ын тогтоолууд;</li> <li>Холбогдох Засгийн газрын тогтоолууд; <ul style="list-style-type: none"> <li>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль</li> <li>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;</li> <li>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;</li> <li>Төрийн аудитын тухай хууль</li> <li>Онцгой албан татварын тухай;</li> <li>Аж ахуйн үйл ажиллагааны</li> </ul> </li> </ul>
2	Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний зохицуулалт, хууль, эрх зүйн орчны хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэхэд дүгнэлт гаргах;	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах,	<ul style="list-style-type: none"> <li>Газрын тосны болон нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэхэд санал,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Холбогдох УИХ-ын тогтоолууд;</li> <li>Холбогдох Засгийн газрын тогтоолууд; <ul style="list-style-type: none"> <li>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль</li> <li>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;</li> <li>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;</li> <li>Төрийн аудитын тухай хууль</li> <li>Онцгой албан татварын тухай;</li> <li>Аж ахуйн үйл ажиллагааны</li> </ul> </li> </ul>

3	Аудитын дүгнэлт зөвлөмж боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах;	гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам"-ын дагуу тус тус мэргэжлийн шинжээч аудитад татан оролцуулах	дүгнэлт боловсруулах.	тусгай зөвшөөрлийн тухай хууль.
---	--	--	-----------------------	---------------------------------

3.2 Гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгэх шинжээч нь аудитын хамрах хүрээний байгууллагуудтай аудитын багаар дамжуулан харилцаж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, энэхүү ажлын даалгаварт тусгасан ажлыг Төрийн аудитын байгууллагаас баримтлах бодлого, чиглэл, зорилтын хүрээнд чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**

4.1 Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг шинжээчийн тайланд тодорхой бичнэ.

4.2 Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй шинжээч ажлын тайландаа гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн ажлын явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

4.3 Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй шинжээч ажлын тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

### **ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

5.1 Шинжээч нь тухайн аудитад оролцоход Төрийн аудитын байгууллагатай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

5.2 Шинжээч нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай байна. Үүнд:

- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний чиглэлээр мэргэжил боловсрол эзэмшсэн, магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэшсэн инженер, багш байх;
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаарх хууль, эрх зүйн орчныг судалж дүгнэлт гаргах чадвартай ба туршлагатай;
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний чиглэлээр судалгаа хийж, ажлын хэсэгт оролцож байсан бол давуу тал болно.

5.3 Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ болон ажлын даалгаварт тодорхойлсон ажлыг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хугацаанд мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

5.4 Нууцлал: Шинжээч /шинжээчийн баг/ нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил дагаж мөрдөнө.

#### **Бүрдүүлэх материал:**

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
- Техникийн санал /үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө/, санхүүгийн дэлгэрэнгүй санал /тусад нь дугтуйлсан байх/;

Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

### **ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

6.1 Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

6.2 Гэрээний дагуу төлбөрийг төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

6.3 Шинжээчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч үнэлж, саналаа Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ. Захиалагчийн өгсөн үнэлгээг үндэслэн санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

6.4 Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

**ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ**

**[огноо]**

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г \_\_\_\_\_ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна.

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: \_\_\_\_\_

Холбоо барих утас: \_\_\_\_\_

## ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

## 3.1. Ерөнхий танилцуулга

.....  
 .....

*(Оролцогч хуулийн этгээд болон хувь хүн /баг/ нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)*

## 3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

*Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд/баг/хувь хүн дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү.*

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: \_\_\_\_\_

## САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

### Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]*

### Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]*

### Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

### Хэлний мэдлэг:

*[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]*

### Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ<sup>1</sup>**

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

**БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ**

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

**АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

- *Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.*
- *Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.*

<sup>1</sup> Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.